



ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ДҮГНЭХ, ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЧАНАРЫГ ХЯНАХ ЖУРАМ /Төсөл/

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Төрийн аудитын байгууллагаас (цаашид “Захиалагч” гэх) шинжээч сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, шинжээчтэй байгуулсан гэрээг дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах харилцаанд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Төрийн аудитын байгууллагатай гэрээний үндсэн дээр хамтран ажиллах шинжээч нь тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тусгай мэдлэг, мэргэшлийн зэрэг, ажлын туршлага бүхий хувь хүн, баг болон хуулийн этгээд байж болох бөгөөд санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэх этгээд нь Аудитын тухай хуулийн 3.1.4-т заасан шаардлагыг¹ хангасан байна.

1.3. Энэхүү журам нь Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

1.4. Аудитын тухай хуулийн 3.1.4-т заасан аудитын хуулийн этгээдийн ажлын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, баталгаажуулахад энэхүү журам үйлчлэхгүй.

ХОЁР. ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

2.1. Аудитад ажиллах шинжээчийн сонгон шалгаруулалтыг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтлан Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэл дэх төрийн аудитын байгууллага зохион байгуулна.

2.2. Төрийн аудитын байгууллага нь дараах тохиолдолд аудитад шинжээчийг гэрээгээр ажиллуулна. Үүнд:

2.2.1. Төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн хүчин чадлаас илүү гарсан ажлыг цаг тухайд нь гүйцэтгэх;

2.2.2. Аудитын явцад гарсан тодорхой асуудлаар нарийн мэргэжлийн дүгнэлт гаргах шаардлагатай болсон;

2.2.3. Аудитын үр дүнд бодлогын зөвлөмж боловсруулах ажилд мэргэжлийн зөвлөгөө авах шаардлагатай болсон;

2.3. Аудитын төрөл, онцлогоос шалтгаалан тавигдах тусгай шаардлагыг ажлын даалгаварт нарийвчлан тусгах бөгөөд дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд:

2.3.1. санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэх этгээд нь аудитын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй аудитын хуулийн этгээд байх;

2.3.2. тухайн мэргэжлээр нарийн мэргэшсэн, эрдмийн зэрэг цолтой болон уг үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий байх;

2.3.3. тухайн салбарт (мэргэжлээрээ) 3-аас доошгүй жил тогтвортой ажилласан байх;

2.3.4. тухайн салбарын (мэргэжлийн) үйл ажиллагааны дүрэм, ёс зүйн зөрчилгүй байх;

2.3.5. тухайн ажлыг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилгүй байх.

2.4. Аудитад ажиллах шинжээчийн ажлын даалгаврыг тухайн аудитыг гүйцэтгэх аудитын баг боловсруулж, МУЕА-ын орлогч (аймаг, нийслэл дэх төрийн аудитын газар Тэргүүлэх аудитор)-оор батлуулна.

¹ 3.1.4. “аудитын хуулийн этгээд” гэж аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нөхөрлөл, компанийг;



2.5. Аудитад ажиллуулах шинжээчийг тухайн аудитыг гүйцэтгэх хугацаанаас богино хугацаагаар ажиллуулна.

2.6. Шинжээчийн ажлын гүйцэтгэл үндэслэлгүй бөгөөд үнэн зөв болох нь эргэлзээтэй тохиолдолд давтан шинжээч ажиллуулж болох бөгөөд өмнө нь ажилласан шинжээчийг дахин ажиллуулахгүй.

2.7. Шинжээчийн гүйцэтгэх ажлын цар хүрээ, ажлын хөлсний хэмжээнээс хамаарч холбогдох бүтцийн нэгж шинжээчийг энэхүү журмын дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулах бөгөөд бусад тохиолдолд МУЕА-ын болон тэргүүлэх аудиторын тушаалаар байгуулагдсан сондгой тоо бүхий 5-7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг шинжээчийг сонгон шалгаруулна.

2.8. Аудитын онцлог, гүйцэтгэх хугацаа, төрийн болон албаны нууцлал зэргээс хамааран энэ журмын 2.7 дахь заалтыг баримтлахгүйгээр МУЕА-ын шийдвэрээр шинжээчтэй шууд гэрээ байгуулж болно.

2.9. Шинжээч сонгон шалгаруулах ажлын хэсэг нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд шинжээч сонгон шалгаруулах мэдлэг, ур чадвар, туршлага бүхий, тухайн салбарын иргэн, хуулийн этгээдтэй сүүлийн 3 жилийн хугацаанд хамаарал бүхий ажил үйлчилгээ эрхлээгүй байх шаардлага тавигдана.

ГУРАВ. ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

3.1. Төрийн аудитын байгууллага нь аудитад шинжээчээр ажиллах шаардлага хангасан хувь хүн, хуулийн этгээдийн цахим мэдээллийн сан үүсгэж, хөтлөх бөгөөд Төрийн аудитын байгууллагад гэрээлэн гүйцэтгэсэн ажлын мэдээлэл, гүйцэтгэлийн үнэлгээг тухай бүр тусгаж, шинжээч сонгон шалгаруулах үйл ажиллагаанд ашиглана.

3.2. Төрийн аудитын байгууллагын худалдан авах ажиллагаа хариуцсан нэгж мэдээллийн санд хамтран ажиллах хүсэлт ирүүлсэн хувь хүн, баг, хуулийн этгээдийг үйл ажиллагааны чиглэл тус бүрээр бүртгэж, цахим мэдээллийн санд оруулна.

3.3. Гүйцэтгэлийн болон нийцлийн аудитад ажиллах шинжээчийг ажлын хөлснөөс хамаарч дараах байдлаар сонгон шалгаруулж, гэрээ байгуулна. Үүнд:

3.3.1. 10 сая хүртэлх төсөвт өртөг бүхий ажлын шинжээчийг мэдээллийн сангийн бүртгэлээс энэхүү журмын 2.3-т заасан ерөнхий шаардлага болон ажлын даалгаварт заасан тусгай шаардлагыг илүү хангасан 3-5 этгээдийн жагсаалт үүсгэн эрэмбэлж, жагсаалтад орсон шинжээч нарт ажлын даалгавар бүхий гэрээ байгуулах санал хүргүүлж, хэлцэл хийнэ.

3.3.2. 10 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий ажлын шинжээчийг сонгон шалгаруулахдаа ажлын урилга, тавигдах шаардлагыг өдөр тутмын сонин болон байгууллагын цахим хуудсаар мэдээлж, хүсэлт ирүүлсэн этгээдээс энэхүү журмын 2.3-т заасан ерөнхий шаардлага болон ажлын даалгаварт заасан тусгай шаардлагыг илүү хангасан 5 доошгүй этгээдийн жагсаалт үүсгэн эрэмбэлж, жагсаалтад орсон шинжээч нарт ажлын даалгавар бүхий гэрээ байгуулах санал хүргүүлж, хэлцэл хийнэ.

3.3.3. Энэ журмын 3.3.1, 3.3.2-т заасан шинжээчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг худалдан авалт хариуцсан бүтцийн нэгж болон хариуцсан ажилтан зохион байгуулах бөгөөд шинжээчийг МУЕА-ын болон аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын тэргүүлэх аудиторын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг сонгон шалгаруулж, дүнг захиалагчид танилцуулна.

3.3.4. Журмын 3.2.1-3.2.3 -т заасны дагуу хэлцэл хийж, хамгийн бага үнэ санал болгосон этгээдийг МУЕА-т танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3.4. Санхүүгийн тайлангийн аудит гүйцэтгэх аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах үе шатанд Санхүүгийн аудит гүйцэтгэх бүтцийн нэгж болон сонгон шалгаруулах ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын бэлтгэл үе шат, сонгон шалгаруулах үе шат, гэрээ байгуулах гэсэн үе шатанд дараах ажиллагааг хийж гүйцэтгэнэ. Үүнд:



3.4.1. Сонгон шалгаруулах бэлтгэл үе шатанд:

3.4.1.1 Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар болон аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын санхүүгийн аудитын баг тухайн жилд аудитын хуулийн этгээдээр санхүүгийн тайлангийн аудит хийлгэх байгууллагын жагсаалт (аудитын төлбөрийн мэдээлэл бүхий) болон холбогдох мэдээллийг ажлын хэсэгт жил бүрийн 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.

3.4.1.2. Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар болон аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын санхүүгийн аудитын баг 3.4.1.1-т заасан жагсаалтыг үндэслэн төсөв захирагчийн хэлбэр, аудитын цагалбарыг харгалзан аудитын үйлчилгээний төлбөр өндөр болон бага дүнтэй байгууллагыг холимог байдлаар багцлан Монгол Улсын Ерөнхий аудитор (аймаг, нийслэлд Тэргүүлэх аудитор)-аар батлуулна.

3.4.1.3. Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газар болон аймаг, нийслэл дэх төрийн аудитын газрын санхүүгийн аудитын баг журмын 3.4.1.2-т заасны дагуу МУЕА-аар батлуулсан багц тус бүрт тавигдах нийтлэг болон тусгай шалгуурыг харгалзан ажлын даалгаврыг бэлтгэж, ажлын хэсэгт жил бүрийн 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.

3.4.2. Сонгон шалгаруулах үе шатанд :

3.4.2.1. Ажлын хэсэг нь мэдээллийн санд бүртгэлтэй аудитын хуулийн этгээдүүдийн өмнөх жилд гэрээгээр гүйцэтгэсэн ажлын чанарын үзүүлэлт, аудит гүйцэтгэх туршлага хуулийн этгээдийн засаглал, хүний нөөцийн чадавх зэргийг эрэмбэлэх;

3.4.2.2. Аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулахад мэдээллийн санд бүртгэлтэй болон сонирхогч этгээдийг нэгээс илүү багцад оролцохгүй байхаар нээлттэй зар, урилга, ажлын даалгаврыг 2-оос доошгүй мэдээллийн сувгаар олон нийтэд мэдээлэх бөгөөд сонирхогч этгээд холбогдох материалыг, оролцох хүсэлтийн хамт ирүүлнэ.

3.4.2.3. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ илэрхийлж, аудитын хуулийн этгээдэд тавигдах нийтлэг шалгуур, ажлын даалгаварт тусгагдсан тусгай шалгууруудыг хангасан талаарх аудитын хуулийн этгээдээс ирүүлсэн бичиг баримтын үнэн зөв, найдвартай байдлыг харгалзан ажлын хэсгийн гишүүдийн олонхын саналаар дүгнэх;

3.4.2.4. Журмын 3.4.2.1-т заасан шалгуур үзүүлэлт нь тухайн жилд сонгон шалгаруулалт оролцохоор шинээр хүсэлт гаргасан, мэдээллийн санд бүртгэлгүй аудитын хуулийн этгээдэд хамаарахгүй.

ДӨРӨВ. ШИНЖЭЭЧТЭЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

4.1. Үндэсний аудитын газар болон Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь үйлчлүүлэгч байгууллага шинжээчтэй “Ажил гүйцэтгүүлэх гэрээ”-г байгуулна.

4.2. Үндэсний аудитын газрын хувьд “Аудитын ажил гүйцэтгүүлэх гэрээ”-г Монгол Улсын Ерөнхий аудитор баталж, Төрөлжсөн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор, үйлчлүүлэгч байгууллага, шинжээчийн эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

4.3. Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын хувьд “Ажил гүйцэтгүүлэх гэрээ”-г Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор баталж, тухайн аудит хариуцсан нэгжийн менежер, үйлчлүүлэгч, шинжээчийн эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна.

4.4. Шинжээч сонгон шалгаруулах ажлын даалгавар нь “Шинжээчийн ажил гүйцэтгүүлэх гэрээ”-ний салшгүй хэсэг байна.



4.5. Төрийн аудитын байгууллага гэрээ байгуулахын өмнө ажлын даалгаварт шинжээчээр гүйцэтгүүлэх аудитын ажлын зорилго, цар хүрээ нь зохистой, хангалттай хэмжээнд тусгагдсан эсэхийг сайтар шалгаж, шинжээчтэй хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж болно.

ТАВ. ШИНЖЭЭЧИЙН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ЧАНАРЫГ ХЯНАХ

5.1. Үндэсний аудитын газар болон аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын холбогдох албан тушаалтнууд шинжээчийн гүйцэтгэсэн ажлын явц, үр дүн, тайлан (дүгнэлт), ажлын баримтад холбогдох албан тушаалтнууд үе шатны хяналт хэрэгжүүлнэ.

5.2. Шинжээч нь гүйцэтгэсэн ажлын тайлан, дүгнэлт, ажлын баримтыг аудитын багт хэвлэмэл байдлаар болон цахимаар хүлээлгэн өгч хянуулах бөгөөд үе шатны хяналт хэрэгжүүлж буй албан тушаалтнууд шаардлагатай тохиолдолд ажлын гүйцэтгэлийн явц, тайлан (дүгнэлт)-ийн талаар дээд шатны албан тушаалтнуудыг оролцуулан танилцуулга, сонсгол зохион байгуулж болно.

5.3. Шинжээч нь чанарын хяналтын хүрээнд аудитын баг болон холбогдох албан тушаалтнаас өгсөн санал, зөвлөмжийг хүлээн авч, ажлын тайлан, дүгнэлт, ажлын баримтад заасан хугацаанд засан сайжруулалт хийх үүргийг хүлээх бөгөөд хүлээн зөвшөөрөгдсөн ажлын гүйцэтгэлийг гэрээнд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад баталгаажуулж ирүүлнэ.

5.4. Бодлогын зөвлөхийн үйл ажиллагааны чанар байдалд Үндэсний аудитын газрын Чанарын баталгаажуулалтын алба хяналт тавина.

5.5. Монгол Улсын Ерөнхий аудитор шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Үндэсний аудитын газрын чанар баталгаажуулалтын аудит хариуцсан нэгжээр шинжээчийн хийсэн ажилд чанарын баталгаажуулалт хийлгэж болно.

5.6. Шинжээч нь чанарын хяналт хэрэгжүүлэх явцад аудитын багаас өгсөн санал, зөвлөмжийг хүлээн авч, тогтоосон хугацаанд хэрэгжүүлээгүй эсхүл шинжээчийн ажлын гүйцэтгэлээс ямар нэг үр дүн гарахгүй нь илт гэж үзсэн тохиолдолд гэрээ байгуулсан албан тушаалтан шинжээчтэй байгуулсан гэрээг цуцлах саналыг холбогдох нотлох баримтын хамт МУЕА-ын орлогчид танилцуулж, МУЕА-аар эцэслэн шийдвэрлүүлнэ.

5.7. Чанарын хяналт хэрэгжүүлж буй албан тушаалтнууд шаардлага хангаагүй тайлан (дүгнэлт), ажлын баримт хүлээн авахыг хориглоно.

ЗУРГАА. ШИНЖЭЭЧТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭГ ДҮГНЭХ

6.1. Аудитыг баг, холбогдох эрх бүхий албан тушаалтан ажлын гүйцэтгэлийг энэхүү журмын Хавсралт 2-ын дагуу дүгнэж, үнэлгээ өгөх бөгөөд шинжээчид танилцуулж, тэмдэглэл хөтлөн харилцан баталгаажуулсан байна.

6.2. Шинжээчийн ажлын гүйцэтгэлийг нийт “100 оноо”-оор дүгнэх бөгөөд онооны үзүүлэлтээс хамаарч, дараах үнэлгээ өгөгдөнө.

- 6.2.1. 80-100 хүртэл оноо “Хангалттай”
- 6.2.2. 60-80 хүртэл оноо “Хангалттай бус”
- 6.2.3. 0-60 хүртэл оноо “Хангалтгүй”

6.3. Үе шатны хяналт хэрэгжүүлж буй албан тушаалтан шинжээчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг гаргаж, гэрээг дүгнэсэн акт үйлдэн ажлын тайлан (дүгнэлт)-г холбогдох ажлын баримтын хамт Тамгын газарт тухай бүр хүргүүлэх бөгөөд Тамгын газар гүйцэтгэлийн үнэлгээнээс хамаарч, гэрээнд заасны дагуу ажлын хөлсийг олгоно.

6.4. Шинжээчийн ажлын гүйцэтгэл “Хангалтгүй” дүгнэгдсэн тохиолдолд тодорхой хугацаа тогтоож, дахин гүйцэтгүүлж болох бөгөөд үе шатны хяналт хэрэгжүүлж буй албан тушаалтан МУЕА-ын орлогчид танилцуулж, шийдвэрлүүлнэ.

6.5. Шинжээч ажлын гүйцэтгэлд өгсөн үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд МУЕА-т хандаж, эцэслэн шийдвэрлүүлж болно.



ДОЛОО. БУСАД

7.1. Шинжээч нь гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд энэ журмын 3.1-т заасан мэдээллийн санд холбогдох нэгж (албан тушаалтан) энэ талаарх бүртгэлийг тухай бүр хөтөлж, төрийн аудитын байгууллагатай 3 жилийн хугацаанд ажил гэрээлэн гүйцэтгэх эрх олгохгүй.

7.2. Шинжээч нь ёс зүйн зөрчил гаргасан, хараат бус байдлыг хангаж ажиллаагүй тохиолдолд Төрийн аудитын байгууллага тухайн асуудлыг хянаж шийдвэрлэх эрх бүхий байгууллага (албан тушаалтан)-д хүсэлт гаргаж шалгуулна.

7.3. Шинжээчийн ажлын гүйцэтгэлийг үндэслэлгүйгээр буруу үнэлсэн болон шинжээчийн шаардлага хангаагүй тайлан (дүгнэлт), ажлын баримт хүлээн авсан нь тогтоогдвол холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---